

АНС-ийн эцэг эхчүүдийн академийн товч видео танилцуулга:

Энэхүү видеог Арлингтоны Нийтийн Сургуулиуд дахь Байгууллагын шийдлийн газраас хийв. Энэхүү мэдээлэл нь Арлингтоны сургалтын удирдлагын тогтолцооны Canvas програмыг хэрхэн ашиглах тухай товч танилцуулга бөгөөд зайны сургалтын үед онлайн зааварчилгаанд дэмжлэг туслалцаа үзүүлэх, зохион байгуулалтанд туслах зорилгоор судлах, танилцах програм дээр оюутнууд ашиглаж болно. Энэхүү мэдээллийг оюутан, эцэг эхчүүдэд зориулан бүтээв.

Технологийн шинэчлэл: LMS – Canvas програм

Тэргүүлэх академийн танилцуулга видео: Оюутнуудад зориулсан компьютер дээрх танилцуулга

Хянах самбар

Сайн байна уу! Бидэнтэй хамт байгаа та бүхэнд баярлалаа.

Энэхүү видеонд Оюутнууд та бүхэн Canvas програмд хэрхэн зохион байгуулалт хийх, хаашаа нэвтрэх, юу хийхээр төлөвлөж байгаа тухай, хэзээ хийх, хэрхэн хийх зэргээр Canvas програмыг хэрхэн удирдах тухай танилцуулна.

Canvas руу нэвтрэн орохдоо таны харах эхний зүйл бол хянах самбар, зүүн талд байх **Ерөнхий удирдлага** мөн баруун талд байх **Хажуугийн талбар хэсэг** зэрэг юм.

ЕРӨНХИЙ УДИРДЛАГА

Canvas програмын **Ерөнхий Удирдлагын Цэс** нь хичээлүүд рүү нэвтрэх, мөн Canvas-ийн бусад талбар, хэсгүүд рүү нэвтрэхэд тусална.

Хаяг линк, холбоосоос та **Мэдэгдэл сонголтыг** өөрчлөх, **Ерөнхий танилцуулгын** зургийг солих, хувийн **Файлуудыг** илгээх, **Хэрэглэгчийн тохиргоог**, **ePortfolios**-ийг удирдах, Canvas програмаас програмаас **Гарах** боломжтой.

Дурын үед Canvas-ийн хянах самбар руу буцахын тулд **Хянах самбар** холбоос дээр дарна.

Өнгөрсөн хугацааны элсэлт зэрэг таны бүх хичээлүүд рүү нэвтрэхийн тулд **Хичээлүүд** линкийг дарна.

Өөрийн нэр болон **Хичээлийн хөтөлбөрөөр** тодорхойлогдох өөрийн **Хувийн хөтөлбөрийг** харахын тулд **Хөтөлбөр** дээр дарна. Сонгосон хичээл эсвэл бүх хичээлийг харах, шүүлт хийх бол календарыг идэвхтэй ба идэвхгүй байдалд шилжүүлж болно. Хөтөлбөрийн хичээлийн агуулгыг тодорхойлох бол **Хичээлийн өнгийг** өөрчилж болно. Дүрсүүд нь төлөвлөгөөний хэлбэрийг тодорхойлоход тусална. Та баталгаажуулалт хийсний дараа программыг орхин гарч болно.

Canvas програмын дотор өөрийн багштай ярилцах, тайлбарыг унших бол **Хүлээн авах хайрцгийг** дарна. Шинэ мессежийг эхлүүлэх бол **Харандааны Зураг** дээр дарах, дараа нь **Хичээлийг Сонгох**, дараа нь **Багш** гэсэн үйлдлүүдийг хийнэ.

Эцэст нь туслах мэдээлэл рүү орох бол **Тусламж** холбоос дээр дарна. Canvas-аар нэмэлт туслалцаа хүсэж байгаа бол **Багш** ба **Сургуулийн Техникийн Тусламж** руу залгана уу.

Хянах самбар руугаа буцацгаая.

ХЯНАХ САМБАР

Хянах самбар нь таны одоогийн бүх хичээлүүдэд дээд түвшний танилцуулга, мэдээлэл өгнө. Та хянах самбарын цонхнуудын хооронд шилжиж болно. үүний тулд эхлээд **Курсын картыг харах—Жагсаалтаар харах—Одоогийн үйл ажиллагааг** сонгохын тулд Сонголтын дүрс дээр дарна.

Мөн үүнээс гадна курсийн картууд дээр өнгийг давхар сонгох боломжтой. Өнгөний сонголтыг арилгах, ил гаргахын тулд Өнгөний давхардалыг сонголтыг хийнэ.

Картыг харах. Энэ бол хамгийн түгээмэл ашиглагддаг цонх юм. **Картыг харах цонх** нь таны дуртай хичээлүүдэд хичээлийн картуудыг харуулна. Хянах самбар дээр шинэ хичээлүүд автоматаар нэмэгдэнэ. Та сонголт хийгээд **чирэх**,

буулгах замаар өөрийн хүссэн дарааллаар хичээлийн картуудыг зохион байгуулах боломжтой.

Курсын картын сонголтоос та хичээлийнхээ өнгийг өөрчилж болно. Календар дээр Курсийн өнгийг хэрхэн өөрчилснийг санаж байна уу? Тэнд таны сонгосон өнгө энэ цонхонд курсийн карт дээр харагдана. Хэрвээ та энд үүнийг өөрчилбөл Хөтөлбөр дээр давхар өөрчлөлт орно.

Карт бүр Зарлан мэдэгдэх, Хэлэлцүүлэгийн адилаар **Сануулга** бүхий зарим дүрс, тэмдэгтэй байж болно.

Хамгийн баруун захынх нь **Хажуугийн талбар** юм. Хажуугийн талбарын бүрэлдэхүүнд төлөвлөгөөний бүртгэлийг хадгалахад туслах **Хийх** жагсаалт багтана. Та төлөвлөгөөг харахын тулд төлөвлөгөөний нэр дээр дарахад хангалттай.

Одоогийн тайлбар дээр багш нарын зүгээс таны баталсан даалгавруудад хийсэн хамгийн сүүлчийн талбарууд харагдана.

Canvas-ийг **жижиг дэлгэцийн нягтралаар** харах үед Хажуугийн талбарын мэдээлэл дэлгэцийн доод тал руу шахагдана.

Хоёрдугаар цонх бол **Жагсаалтаар харах** юм. **Жагсаалтаар харах** дээр хичээлүүдийн хооронд даалгавруудыг удирдах, зохион байгуулахад туслах зорилгоор **Төлөвлөгөөг харах**

дотор бүх хичээлийн **Даалгаварыг** харуулна.

Жагсаалтаар харах нь одоогийн огноо руу нээгдэнэ. Өнгөрсөн болон ирээдүйн мэдээллийг харах бол хуудсыг дээш, доош гүйлгэж болно. одоогийн огноо руу түргэн буцах бол дээд талд байх **Өнөөдөр** гэсэн товчлуурыг дарахад хангалттай.

Жагсаалтаар харах цонхноос та **Боломж нөхцлийг сануулах цэсийг** харах боломжтой. **Боломж нөхцлийг сануулах цэс** нь таны түвшинг ахиулахад туслах зорилгоор нэг байрлалаар бүх дутуу төлөвлөгөөнүүдийг харуулна.

Dashboard-ийн хамгийн сүүлчийн цонх бол **Одоогийн үйл ажиллагаа** гэсэн сонголт юм. **Одоогийн үйл ажиллагаа** гэсэн цонхон дээр **Зарлан мэдэгдэх, Санал солилцох, Даалгавар төлөвлөгөө, Хэлэлцэх, Харилцагчийг шалгах** зэрэг таны хичээлүүдийн мэдэгдлүүд харагдана. Шинэ болон уншигдаагүй мэдээлэл нь уншигдаагүй дүрс байдлаар харагдана. Илүү Ихийг Харуулах холбоосыг дарснаар бүх үйл ажиллагааны хэлбэрийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг харж болно.

Эдгээр бүх цонхнууд нь таныг өөрийн анги, түвшний талаар бүрэн мэдээлэл авахад тусална. Гэхдээ одоо бүгдээрээ Картыг харах сонголт руу буцаж, хичээлээ шалгацгаая.

ХИЧЭЭЛҮҮД

Та нэвтрэхийг хүсэж байгаа **Хичээлийн Нэр** дээр дараарай. Хичээл рүү нэвтрэх үед та дунд хэсэгт нь **Эх хуудас** гарч ирнэ. Мөн баруун тал руу Хажуугийн талбар, мөн **Хичээлийн цэс, Курсийг удирдах** линк гарч ирнэ.

Танай багш тусгай нэгж, модул руу нэвтрэх, удирдахад туслах зорилгоор **Эх Хуудас Сонголтыг** байгуулсан. Тэнд аль нэг сонголт рүү нэвтрээд **Дараагийн эсвэл Өмнөх** товчлуурыг дараарай. Хичээлийг Удирдах, Жолоодох дээр **Эх хуудас** холбоосыг дарах эсвэл өмнө нь нэвтэрсэн хуудсуудад харагдах хичээлийн нэр дээр дарснаар хичээлийн эх хуудас руу буцна.

Курсийг удирдах цэсэн дээр **Зарлан мэдэгдэх, Хичээлийн хөтөлбөр, Анги** рүү нэвтрэх холбоос, мөн бусад багажууд, хичээлийн талбарууд зэргийг агуулна. Мөн **Сан, нөөцийн** холбоосыг харж болно. Та баталгаажуулалт хийсэн зүйлсээ харах төлөвлөгөөг хэрхэн зохион байгуулсан болон хариу мэдээллийг харах бол Курсийг удирдах цонхонд **Анги** гэсэн сонголтон дээр дарна. Багшийн тайлбарт хариу явуулах бол баталгаажуулалт хийсэн төлөвлөгөө рүү нэвтэрнэ. **Жич. Canvas програм дахь тухайн тухай анги, түвшин нь тодорхой төлөвлөгөөнд зориулагдсан бөгөөд та анги, түвшний бүрэн мэдээллийг харах бол StudentVue эсвэл ParentVue-ийг шалгах хэрэгтэй.**

Бараан талын Хажуугийн талбар нь Хянах самбарын Хажуугийн Талбартай төстэй. Хянах самбарын Хажуугийн талбар нь бүх хичээлүүдэд харагддаг. Харин хичээлийн жагсаалтын Хажуугийн талбар нь тухайн хичээлдээ харагдана. Төлөвлөгөөг харах бол төлөвлөгөөний нэр дээр дарна. Харин төлөвлөгөөг баталгаажуулан илгээх бол **Даалгаврыг илгээх** товчлуурыг дарна. Хичээлийг удирдах дээр Эх хуудасны холбоосыг дарах эсвэл өмнө нь нэвтэрсэн цонхнуудын жагсаалтаас хичээлийн нэр дээр дарж буцах үйлдэл хийнэ.

Мөн Хажуугийн талбар нь даалгаварт өгөгдсөн одоогийн мэдээлэл, санал хүсэлт зэргийн талаар мэдэх боломж олгоно. Даалгаврын нэр дээр дарж, Илгээх тухай дэлгэрэнгүй мэдээлэл хуудсан дээр тайлбарыг шалгана.

Энэхүү видео танилцуулга нь Canvas програмын талаар товчхон ч гэсэн мэдээлэл авч, хаашаа, ямар цонх руу орох, ямар үйлдэл хийгдэх, хэзээ хийгдэх, хэрхэн хийх зэрэг талаар тодорхой ойлголт авсан байх гэж найдаж байна.